



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 602

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хандиваар бий болсон нийт 203,429,160.00 (хоёр зуун гурван сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун жаран) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг, зөвшөөрсүгэй.

2.Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан Сумын засаг даргын 2020 оны А/02 захирамжаар олгосон Эрдэнэцагаан сум 2 дугаар багт байрлах 2 дугаар хавсралтад заасан газар эзэмших эрхийг Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын биет бус хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Хошууч генерал Г.Ариунбуян, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын дарга, Дэд хурандаа Б.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006985

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
602 дугаар тогтоолын хавсралт

**ХАНДИВААР БИЙ БОЛСОН СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗАРТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
Барилга байгууламж						
1	Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн конторын барилга (Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум 2 дугаар баг)	2020.06.22	М2	481	406,239.42	195,401,160.00
хэсгийн дүн				481		195,401,160.00
Тавилга эд хогшил						
2	Ширээ, сандал /1.40/	2019.08.22	ш	4	456,000.00	1,824,000.00
3	Ширээ, сандал /1.60/	2019.08.22	ш	1	570,000.00	570,000.00
4	Ширээ, сандал /1.80/	2019.08.22	ш	1	1,140,000.00	1,140,000.00
5	Сандал	2019.08.22	ш	31	30,400.00	942,400.00
6	Ор	2019.08.22	ш	2	684,000.00	1,368,000.00
7	Ширээ	2019.08.22	ш	15	83,600.00	1,254,000.00
8	Оффисс ширээ	2019.08.22	ш	2	98,800.00	197,600.00
9	Гал тогооны ширээ	2019.08.22	ш	4	60,000.00	240,000.00
10	Гал тогооны сандал	2019.08.22	ш	16	18,250.00	292,000.00
11	Торх	2019.08.22	ш	1	200,000.00	200,000.00
хэсгийн дүн				77		8,028,000.00
Нийт дүн						203,429,160.00 (хоёр зуун гурван сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун жаран)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
102 дугаар тогтоолын хавсралт

**СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ
БҮРТГЭХ БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх /Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум 2 дугаар баг Зотол -3, 300 тоот/	2020.01.07	м.кв	2892	34,704,000.00
Нийт дүн					34,704,000.00
					(гучин дөрвөн сая долоог зуун дөрвөн мянга)